



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /11/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 86

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ИТХ-ЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ГАНБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгуулагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгслийн дансны үлдэгдэлд 58,700.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 23,439.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Прадо 105 маркийн авто машин бүртгэлтэй байх ба уг машин нь бодитоор байхгүй. Мөн байгууллагын дансанд бүртгэлгүй Ланд 100 маркийн 62-58 ОРО улсын дугаартай автомашинд 12,000.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн ба тайлангийн хугацаанд авто машинд 5,200.0 мянган төгрөгийн мотор сольж тавьсан боловч капиталжуулаагүй зардалд бүртгэсэн байна. Аудитын сорилоор түүвэрт хамрагдсан 71,336.3 мянган төгрөгийн үлдэгдэлд жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллогыг хийж баталгаажуулаагүй тул дүгнэлт өгөх боломжгүй гэж үзэж хязгаарлав. Энэ нь УСНББОУС 17-ийн 17 параграф

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

“...сэлбэг, нөөцөд байгаа тоног төхөөрөмж, засвар хийгдэж байгаа тоног төхөөрөмж гэх мэт зүйлс нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд энэ УСНББОУС-д хүлээн зөвшөөрнө” гэсэн стандартын заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг зөрчсөн ба үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1 744 182,90</u>	<u>1 989 182,90</u>
33	АВЛАГА	56 422,90	56 422,90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	56 422,90	56 422,90
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>1 687 760,00</u>	<u>1 932 760,00</u>
351	Түүхий эд материал	<u>591 000,00</u>	<u>836 000,00</u>
35110	Тусгай зориулалттай материал	591 000,00	836 000,00
354	Хангамжийн материал	<u>1 096 760,00</u>	<u>1 096 760,00</u>
35410	Бичиг хэргийн материал	311 860,00	311 860,00
35420	Аж ахуйн материал	784 900,00	784 900,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>83 906 233,76</u>	<u>69 403 856,76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	83 906 233,76	69 403 856,76
392	Биет хөрөнгө	83 706 233,76	69 270 523,48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68 075 000,00	58 700 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22 976 666,39)	(22 501 666,55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41 804 300,00	41 804 300,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16 015 726,73)	(21 794 763,45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19 043 600,00	21 248 600,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6 224 273,12)	(8 185 946,52)
393	Биет бус хөрөнгө	<u>200 000,00</u>	<u>133 333,28</u>
39301	Програм хангамж	375 000,00	375 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(175 000,00)	(241 666,72)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>85 650 416,66</u>	<u>71 393 039,66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>182 146,20</u>	<u>243 146,20</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>182 146,20</u>	<u>243 146,20</u>
413	Өглөг	<u>182 146,20</u>	<u>243 146,20</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	21 032,20	30 032,20
4136	Бусад өглөг	<u>161 114,00</u>	<u>213 114,00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	120 234,00	172 234,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	40 880,00	40 880,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>85 468 270,46</u>	<u>71 149 893,46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>85 468 270,46</u>	<u>71 149 893,46</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11 307 200,00	11 307 200,00
51101	Өмч: - төрийн	11 307 200,00	11 307 200,00
512	Хуримтлагдсан үр дүн	<u>72 264 299,20</u>	<u>57 945 922,20</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	72 264 299,20	72 264 299,20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14 318 377,00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 896 771,26	1 896 771,26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>85 650 416,66</u>	<u>71 393 039,66</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	185 633 600,00	168 913 700,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220 000,00	-
120	Нийтлэг татварын бус орлого	220 000,00	-
120001	Хувьцааны ногдол ашиг	220 000,00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185 413 600,00	168 913 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3 000 000,00	3 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3 000 000,00	3 000 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182 413 600,00	165 913 700,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182 413 600,00	165 913 700,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	180 440 962,94	182 060 201,79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180 440 962,94	182 060 201,79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166 421 883,62	158 464 118,64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56 209 011,37	56 863 542,15
210101	Үндсэн цалин	42 141 255,90	43 112 810,63
210102	Нэмэгдэл	14 067 755,47	13 750 731,52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 378 859,31	6 402 398,70
210201	Тэтгэврийн даатгал	6 567 402,63	4 433 769,82
210202	Тэтгэмжийн даатгал	703 282,79	494 249,37
210203	ҮОМШӨ-ний даатгал	562 826,24	395 399,57
210204	Ажилгүйдлийн даатгал	138 782,83	90 481,20
210205	Эрүүл мэндийн даатгал	1 406 564,82	988 498,74
2104	Хангамж, бараа материалын зардал	14 800 000,00	15 511 600,00
210401	Бичиг хэрэг	1 620 000,00	2 916 000,00
210402	Тээвэр, шатахуун	11 640 000,00	10 446 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 140 000,00	1 377 600,00
210404	Ном, хэвлэл	400 000,00	772 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18 500 000,00	12 000 000,00
210604	Урсгал засвар	18 500 000,00	12 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	394 000,00	30 397 000,00
210702	Дотоод албан томилолт	394 000,00	400 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	29 997 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42 940 650,00	10 153 506,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42 265 000,00	9 999 746,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540 000,00	-
210803	Даатгалын үйлчилгээ	135 650,00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	131 760,00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24 199 362,94	27 136 071,79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9 437 200,00	11 600 570,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14 762 162,94	15 535 501,79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14 019 079,32	23 596 083,15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2 600 000,00	12 252 900,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8 207 200,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 600 000,00	4 045 700,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11 375 079,32	11 296 083,15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11 375 079,32	11 296 083,15
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44 000,00	47 100,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44 000,00	47 100,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5 192 637,06	(13 146 501,79)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1 171 875,21
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1 171 875,21
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1 171 875,21)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5 192 637,06	(14 318 377,00)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны хувь
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11 307 200,00	1 896 771,26	57 722 022,20	70 925 993,46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(14 318 377,00)	(14 318 377,00)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11 307 200,00	1 896 771,26	43 403 645,20	56 607 616,46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	185 413 600,00	168 913 700,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185 413 600,00	168 913 700,00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3 000 000,00	3 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3 000 000,00	3 000 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	182 413 600,00	165 913 700,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182 413 600,00	165 913 700,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	185 413 600,00	168 913 700,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185 413 600,00	168 913 700,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171 394 520,68	145 317 616,85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56 209 011,37	56 854 542,15
210101	Үндсэн цалин	42 141 255,90	43 103 810,63
210102	Нэмэгдэл	14 067 755,47	13 750 731,52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 378 859,31	6 402 398,70
210201	Тэтгэврийн даатгал	6 567 402,63	4 433 769,82
210202	Тэтгэмжийн даатгал	703 282,79	494 249,37
210203	ҮОМШӨ-ний даатгал	562 826,24	395 399,57
210204	Ажилгүйдлийн даатгал	138 782,83	90 481,20
210205	Эрүүл мэндийн даатгал	1 406 564,82	988 498,74
2104	Хангамж, бараа материалын зардал	14 200 000,00	15 704 600,00
210401	Бичиг хэрэг	1 620 000,00	3 161 000,00
210402	Тээвэр, шатахуун	11 040 000,00	10 446 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 140 000,00	1 377 600,00
210404	Ном, хэвлэл	400 000,00	720 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37 999 800,00	14 205 000,00
210604	Урсгал засвар	18 500 000,00	12 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	394 000,00	30 397 000,00
210702	Дотоод албан томилолт	394 000,00	400 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	29 997 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43 775 650,00	10 153 506,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42 900 000,00	9 999 746,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540 000,00	-
210803	Даатгалын үйлчилгээ	135 650,00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	131 760,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9 437 200,00	11 600 570,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9 437 200,00	11 600 570,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14 019 079,32	23 596 083,15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2 600 000,00	12 252 900,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	8 207 200,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 600 000,00	4 045 700,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11 375 079,32	11 296 083,15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11 375 079,32	11 296 083,15

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	44 000,00	47 100,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44 000,00	47 100,00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах		2 205 000,00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	181414100,00	171038520,68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	181414100,00	171038520,68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179414100,00	169038520,68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66459600,00	56209011,37
210101	Үндсэн цалин	52191600,00	42141255,90
210102	Нэмэгдэл	14268000,00	14067755,47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9571500,00	9378859,31
210201	Тэтгэврийн даатгал	6735500,00	6567402,63
210202	Тэтгэмжийн даатгал	709000,00	703282,79
210203	ҮОМШӨ-ний даатгал	567200,00	562826,24
210204	Ажилгүйдлийн даатгал	141800,00	138782,83
210205	Эрүүл мэндийн даатгал	1418000,00	1406564,82
2104	Хангамж, бараа материалын зардал	13000000,00	13000000,00
210401	Бичиг хэрэг	1620000,00	1620000,00
210402	Тээвэр, шатахуун	9840000,00	9840000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 140 000,00	1 140 000,00
210404	Ном, хэвлэл	400 000,00	400 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38 000 000,00	37 999 800,00
210602	Тавилга	19 500 000,00	19 499 800,00
210604	Урсгал засвар	18 500 000,00	18 500 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 000 000,00	138 000,00
210702	Дотоод албан томилолт	1 000 000,00	138 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41 942 000,00	42 875 650,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41 000 000,00	42 000 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540 000,00	540 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	180 000,00	135 650,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22 000,00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200 000,00	200 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9 441 000,00	9 437 200,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9 441 000,00	9 437 200,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2 000 000,00	2 000 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2 000 000,00	2 000 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 000 000,00	2 000 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	182 363 600,00	182 413 600,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	182 363 600,00	182 413 600,00

	САНХҮҮЖИХ		
132001	Орон нутгийн төсвөөс	182 363 600,00	182 413 600,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2 956 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 956 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 356 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	1 200 000,00
210402	Тээвэр, шатахуун	1 200 000,00
2107	Томилолт, зочны зардал	256 000,00
210702	Дотоод албан томилолт	256 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	44 000,00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	44 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3 000 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3 000 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын ИТХ нь Жаргалант сумын иргэдийн ашиг сонирхлыг дээдлэн хамгаалах, иргэдэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч дээд шатанд хүргүүлэх байгууллага юм. Мөн дараах чиг үүрэгтэй ажилладаг байна. Үүнд:

- Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;
- Хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;
- Сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.
- Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу нийтийн сонсгол явуулах хүсэлт гаргах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад багийн нийтийн хурлын зөвлөлөөс сонгогдсон хүмүүсийг даргын тушаалаар батлуулан дотоод хяналтаар ажилладаг байна. Дотоод хяналт нь тухайн онд хийх ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулж, үр дүнг тайлагнан ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 165,913.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,659.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,161.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,257.4 мянган төгрөгөөр буюу 17 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	56.4	56.4	0.0
Бараа материал	1,687.8	1,932.8	245.1
Үндсэн хөрөнгө	83,906.2	69,403.8	(14,502.4)
Нийт хөрөнгө	85,650.4	71,393.0	(14,257.4)
Өр төлбөр	182.1	243.1	61.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	85,468.3	71,149.9	(14,318.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	85,650.4	71,393.0	(14,257.4)

Бараа материалын данс 1,932.8 мянган төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 245.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн бараа материалын орлого зарлагын дүнгээс хамаарсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 14,502.4 мянган төгрөгөөр буурсан нь Орхон аймгийн Засаг даргын А/808 дугаар захирамжийн дагуу 9,375.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталсан болон тайлант хугацааны элэгдлээр буурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 71,149.9 мянган төгрөг болж 14,318.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 166,851.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 166,851.2 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, 937.6 мянган төгрөгөөр бууруулан төсвийг 165,913.6 мянган төгрөгөөр батласан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 165,913.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтаар санхүүжсан. Уг санхүүжилтаас урсгал үйл ажиллагаанд 145,317.6 мянган төгрөгийг зарцуулж, 11,343.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 145,317.6 мянган төгрөг буюу нийт санхүүжилтаас 87.5 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 3,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлох” гэсэн заалтын дагуу нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тооцож тайлагнах.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ нь 2021 онд нийт 124,362.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 105,412.5 мянган төгрөгийн 113 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, 19,219.8 мянган төгрөгийн 37 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,293.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн ба 238.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,055.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага	1	238.5	1	238.5			
Зөвлөмж	1	1,055.0	1	1,055.0			
Нийт дүн	2	1,293.5	2	1,293.5			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалингийн тооцооллыг нягталж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомж, заавар журмын дагуу зөв бодож татвар нийгмийн даатгалын тайлангуудтай таарч байгааг тулган баталгаажуулах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 108,804.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 164.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 106,623.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 албан шаардлага, 2,015.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

1. Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй баяр ёслол уралдаан тэмцээний арга хэмжээнд 31,960.8 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан мөн 2,205.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нийт 34,166.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансанд нийт 37 мэдээлэл хоцроож, 30,660.0 мянган төгрөгийн гүйлгээг огт мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

3. Авлага өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Өмнөх оны аудитаар өгсөн авлага өглөг үүсгэхгүй байх гэсэн зөвлөмжийг биелүүлээгүй тайлангийн хугацаанд 56.4 мянган төгрөгийн авлага, 243.1 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

4. Жилийн эцсийн бараа материал болон үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Тайлангийн хугацааны эцэст нийт хөрөнгөнд тооллого хийх тушаал гаргаагүй, тооллого хийж тооцоо бодсон баримт байхгүй, жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”: 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

5. Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал

Нийгмийн даатгалын тайланд цалинг илүү дутуу тайлагнаснаас нийгмийн даатгалын шимтгэлийг 616.9 мянган төгрөг илүү, 241.5 мянган төгрөг дутуу тооцоолсон байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

6. Үндсэн хөрөнгийн тайлагналтай холбоотой асуудал

Жаргалант сумын ИТХ-ын санхүүгийн бүртгэлд 58,700.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 23,439.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Прадо 105 маркийн авто машин бүртгэлтэй ба уг машин нь бодитоор байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах” гэсэн заалттай зөрчилдөж байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

7. Үндсэн хөрөнгийн тайлагналтай холбоотой асуудал

Тайлангийн хугацаанд авто машинд 5,200.0 мянган төгрөгийн мотор сольж тавьсан боловч капиталжуулаагүй зардалд бүртгэсэн байна. Байгууллагын дансанд бүртгэлгүй Ланд100 маркийн 62-58 ОРО улсын дугаартай автомашинд 12,000.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн байна. УСНББОУС 17-ийн 17 параграф сэлбэг, нөөцөд байгаа тоног төхөөрөмж, засвар хийгдэж байгаа тоног төхөөрөмж гэх мэт зүйлс нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд энэ УСНББОУС-д хүлээн зөвшөөрнө гэсэн заалтын дагуу хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийн найдвартай хэмжиж чадах хөрөнгийг хөрөнгийн өртөгт капиталжуулан бүртгэх, Төсвийн тухай хуулийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудтай зөрчилдөж байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

4.2 Акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу и-баримтгүй 164.5 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "...дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн тул акт хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн дансанд сорил гүйцэтгэхэд цалингийн хүснэгтээрх цалин, нийгмийн даатгалын тайлангийн цалин хоорондоо 1,922.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Цалинг тооцохдоо татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомж, заавар журмын дагуу зөв бодож татвар нийгмийн даатгалын тайлангуудтай тулган баталгаажуулж байх.

2. Хувь хүний орлогын албан татварын тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд олгодог урамшуулалын мөнгөнөөс ХХОАТ-ыг нийгмийн даатгалын шимтгэл хасаагүй дүнгээс тооцож буруу тооцоолон 93.0 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутгасан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14.1-д "Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна" гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн дотоод журманд заасан нэг удаагийн тэтгэмж, тусламжуудаас ХХОАТ тооцоогүй байгаа нь тус хуулийн 22.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж татвараас чөлөөлөгдөнө" гэж заасан үүнд дотоод журманд заасан тусламж тэтгэмжүүд багтахгүй тул ХХОАТ суутгаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг баримталж, НДШ хассан дүнгээс татвар тооцох. Мөн хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжээс бусад тусламж тэтгэмжүүдээс татвар суутгаж байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын ИТХ	10	108,804.1			1	164.5	7	106,623.9	2	2,015.7
Нийт		10	108,804.1			1	164.5	7	106,623.9	2	2,015.7

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

